



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 418

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн даатгалын
санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх
хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын
сонгон шалгаруулалт зохион байгуулах,
журам батлах тухай

Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2008 оны 172 дугаар тогтоолоор баталсан “Улсын төсөв болон даатгалын сангийн санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг сонгох журам”-ын 1.5, 1.6, 2.1 дэхь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр 2014-2015 онд тусламж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын сонгон шалгаруулалтыг 2013 оны 11 дүгээр сард багтаан шуурхай зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нар болон Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Я. Буянжаргал/-т тус тус үүрэг болгосугай.

2. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалтанд хамрагдах тусламж, үйлчилгээний төрөл, шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалын журмыг нэгдүгээр, сонгон шалгаруулалтын урилгын загварыг хоёрдугаар, улс, бүсийн хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг гуравдугаар, улс, бүсийн хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах комиссын үйл ажиллагааны зардлыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

002792

3. Сонгон шалгаруулах комиссын дүгнэлтийг үндэслэн, сонгон шалгаруулалтад орж тэнцсэн, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын талаар холбогдох шийдвэрийг гаргуулж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Сангийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газар /Ц.Цолмонгэрэл/-т даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2010 оны "Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт авах эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалтад хамрагдах тусламж, үйлчилгээний төрөл, хамрах хүрээ, хугацаа, шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачлалыг батлах тухай" 200 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

САЙД



Н.УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 11 сарын 08 өдрийн
418 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНХҮҮЖИЛТЭЭР
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ХУВИЙН ХЭВШЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД
ХАМРАГДАХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТ, ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛЫН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулахад энэхүү журмыг баримтална.

1.2. Улс, бүсийн хэмжээний үйлчилгээтэй болон гадаадын хөрөнгө оруулалттай хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах үүргийг энэхүү тушаалаар байгуулагдсан комисс, Аймаг, нийслэлийн хэмжээнд тусламж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах үүргийг Аймаг, нийслэлийн Засаг даргын томилсон комисс тус тус гүйцэтгэнэ.

1.3. Комисс нь дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байна. Комиссын бүрэлдэхүүнд эрүүл мэнд, санхүү, нийгмийн даатгал, мэргэжлийн хяналт болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, иргэний төлөөлөл орсон байна.

1.4. Комисс нь сонгон шалгаруулалттай холбоотой асуудлыг хурлаараа хэлэлцэн шийдвэрлэнэ.

1.5. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагаас эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр үзүүлэх тусламж, үйлчилгээний төрлийг Эрүүл мэндийн салбарт хөгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар баримтлах бодлогын үндсэн зарчим, түүнчлэн орон нутгийн ба төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас хүн амд үзүүлж байгаа боловч, одоогийн байдлаар орон нутагт тоо, чанар, хүртээмжийн хувьд хангалтгүй, ачаалал, хүлээгдэл ихтэй, цаашид өргөжүүлэн хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээтэй хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ, сэргээн засах тусламж, үйлчилгээг гүйцэтгүүлэх чиглэлийг баримтална.

1.5.1. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээг тухайн орон нутгийн хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгаан, түүнчлэн орон нутгийн ба төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тусламж, үйлчилгээний ачааллыг хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай хуваалцах, тусламж, үйлчилгээтэй холбоотой хүлээгдлийг бууруулах, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг сайжруулахын тулд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн саналд үндэслэсэн болно.

1.5.2.Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээг орон нутгийн ба төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагууд үзүүлж байгаа боловч улсын хэмжээнд тоо, чанар, хүртээмжийн хувьд хангалтгүй байгаа тул хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр хөнгөвчлөх тусламж үйлчилгээг үзүүлэх хувийн хэвшлийн эмнэлэг нь хүний нөөц, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн болон бусад шаардлагыг хангасан тохиолдолд сонгон шалгаруулна.

1.5.3.Уламжлалт анагаах ухааны зонхилон тохиолдох өвчнийг оношлох, эмчлэх стандартын дагуу тухайн орон нутгийн хүн амын дунд зонхилж буй өвчин, эмгэгийг эмчлэн илааршуулах, орон нутгийн болон төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн тусламж, үйлчилгээний ачааллыг хуваалцах зорилгоор уламжлалт эмчилгээ, үйлчилгээг хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх хувийн хэвшлийн эмнэлгийг сонгон шалгаруулна.

1.5.4.Сэргээн засах тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан төрөлжсөн мэргэжлийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх, хөгжүүлэх чиглэлийн дагуу дараах байдлаар тусламж, үйлчилгээг тодорхойлж хамруулна.

А.Өвчин, эмгэг гэмтэл бэртлийн улмаас үүссэн үр дагаврыг арилган хэвийн байдалд оруулахад чиглэсэн дараах төрлийн сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлэх хувийн хэвшлийн эмнэлэг, сувилалыг/Рашаан сувилал/ сонгон шалгаруулна. Үүнд:

- Тархины цус харвалтын дараах сэргээн засах тусламж, үйлчилгээ
- Зүрхний шигдээсийн дараах сэргээн засах тусламж, үйлчилгээ
- Гэмтлийн дараах сэргээн засах тусламж, үйлчилгээ
- Тархины саажилттай хүүхдийн сэргээн засах тусламж, үйлчилгээ
- Түлэгдэлтийн дараах сэргээн засах тусламж, үйлчилгээ
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх сэргээн засах тусламж, үйлчилгээ
- Зүрх, уушиг, бөөр, элэг болон үе мөч, тулгуур эрхтнүүдийн хүнд эмгэгийн улмаас хийгдсэн мэс засал эмчилгээний дараах сэргээн засах тусламж, үйлчилгээ

Б.Чанар, нөөц нь тогтоогдсон рашаан ус, шавар, байгалийн бусад хүчин зүйлийг ашиглаж хийх сэргээн засах тусламж, үйлчилгээг үзүүлэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулна.

1.6.Сонгон шалгаруулалтад оролцож буй хувийн хэвшлийн эмнэлэг, сувиллын үзүүлэх тусламж, үйлчилгээ нь тухайн байгууллагын тусгай зөвшөөрөлд заасны дагуу тогтоогдоно.

1.7.Комисс нь энэ тушаалд заасан тусламж, үйлчилгээний төрлүүдээр тухайн орон нутгийн хүн амын эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэрэгцээ, үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн эмнэлэг, сувиллын хүчин чадалд нийцүүлэн, тухайн жилд батлагдсан орны тоонд багтаан сонгон шалгаруулалтыг явуулна.

1.8. Комисс нь сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан тухай тайлан, дүнг Эрүүл мэндийн яаманд Аймаг, нийслэлийн Засаг даргын албан тоотоор ирүүлнэ.

1.9.Сонгон шалгаруулалтыг хоёр жил тутам зохион байгуулна.

Хоёр. Тусламж үйлчилгээний төрөл:

Д/д	Аймаг, хот	Тусламж үйлчилгээний төрөл			
		Хэвтүүлэн эмчлэх Тусламж, үйлчилгээ	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	Уламжлалт эмчилгээ	Сэргээн засах тусламж, үйлчилгээ
1	Архангай	Дотор (зүрх судас, бөөр), хүүхэд, эмэгтэйчүүд, мэдрэл	✓	✓	✓
2	Баян-Өлгий	Дотор (зүрх судас, хоол боловсруулах, амьсгалын эрхтэн, бөөр), мэдрэл, мэс засал	✓	✓	-
3	Баянхонгор	Дотор (зүрх судас, хоол боловсруулах бөөр), мэдрэл, хүүхэд, чих хамар хоолой, гэмтэл	✓	-	✓
4	Булган	Дотор (зүрх судас, хоол боловсруулах, амьсгалын эрхтэн, бөөр), нүд, мэдрэл, хүүхэд	✓	✓	-
5	Говь-Алтай	Дотор (зүрх судас, хоол боловсруулах, бөөр), мэс засал	✓	✓	✓
6	Говьсүмбэр	-	-	-	-
7	Дархан-Уул	Дотор (зүрх судас, хоол боловсруулах, амьсгалын эрхтэн, дотоод шүүрэл), чих хамар хоолой, мэдрэл, хүүхэд эмэгтэйчүүд	✓	✓	✓
8	Дорноговь	Дотор (зүрх судас, хоол боловсруулах, амьсгалын эрхтэн) хүүхэд, мэс засал	✓	✓	✓
9	Дорнод	Дотор (зүрх судас, хоол боловсруулах), мэдрэл	✓	-	-
10	Дундговь	Дотор (зүрх судас, хоол боловсруулах, амьсгалын эрхтэн, бөөр)	✓	✓	-
11	Завхан	Дотор (зүрх судас, хоол боловсруулах, бөөр), мэдрэл	✓	-	✓
12	Орхон	Дотор (хоол боловсруулах), эмэгтэйчүүд, чих хамар хоолой	✓	✓	-
13	Өвөрхангай	Дотор (зүрх судас, хоол боловсруулах, бөөр), хүүхэд, эмэгтэйчүүд	✓	✓	✓
14	Өмнөговь	Дотор/хоол боловсруулах/ эмэгтэйчүүд, хүүхэд	✓	✓	-
15	Сүхбаатар	Дотор (зүрх судас, хоол боловсруулах, бөөр), хүүхэд, мэдрэл	✓	-	-

16	Сэлэнгэ	Дотор (хоол боловсруулах, амьсгалын эрхтэн, бөөр), эмэгтэйчүүд, хүүхэд, чих хамар хоолой, мэдрэл	✓	✓	✓
17	Төв	Дотор (амьсгалын эрхтэний эмгэг), мэдрэл	✓	✓	✓
18	Увс	Дотор (зүрх судас, хоол боловсруулах, бөөр)мэс засал, эмэгтэйчүүд, мэдрэл, нүд	✓	✓	✓
19	Ховд	Дотор (зүрх судас, хоол боловсруулах, амьсгалын эрхтэн, бөөрний эмгэг), мэдрэл, мэс засал	✓	✓	-
20	Хөвсгөл	Дотор (хоол боловсруулах, амьсгалын эрхтэн, бөөр), эмэгтэйчүүд, мэс засал	✓	✓	-
21	Хэнтий	Дотор (зүрх судас, хоол боловсруулах, амьсгалын эрхтэн), хүүхэд	✓	✓	✓
22	Улаанбаатар хот				
22.1	Улс, бүсийн хэмжээнд үйлчилгээ үзүүлдэг болон гадаадын хөрөнгө оруулалттай эрүүл мэндийн байгууллагууд	Төрөлжсөн мэргэжлийн лавлагаа тусламж, үйлчилгээ: Дотор(зүрх судас, хоол боловсруулах, амьсгалын эрхтэн, бөөр, уушиг, үе мөч, дотоод шүүрэл) эмэгтэйчүүд, мэс засал, нүд, хүүхэд, чих хамар хоолой, гэмтэл, сэтгэц, мэдрэл	✓	✓	✓
22.2	Нийслэлийн хэмжээнийн хүн амд тусламж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд	Дотор (зүрх судас, хоол боловсруулах, амьсгалын эрхтэн, бөөр, уушиг, үе мөч, дотоод шүүрэл) эмэгтэйчүүд, мэс засал, нүд, хүүхэд, чих хамар хоолой, гэмтэл, сэтгэц, мэдрэл	✓	✓	✓
22.3	Нийслэлийн зарим дүүргийн хүн амд мэс заслын тусламж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд	Баянгол дүүргийн хүн амд үзүүлэх мэс заслын тусламж үйлчилгээ			
		Чингэлтэй дүүргийн хүн амд үзүүлэх мэс заслын тусламж, үйлчилгээ			
		Хан –Уул дүүргийн хүн амд үзүүлэх мэс заслын тусламж, үйлчилгээ			
		Сонгинохайрхан дүүргийн хүн амд үзүүлэх мэс заслын тусламж, үйлчилгээ			
		Нийслэлийн төвийн 6 дүүргийн хүн амд үзүүлэх гэмтлийн тусламж, үйлчилгээ			

64

Гурав. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт:

3.1. Сонгон шалгаруулалтад оролцох хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад тавих шалгуур үзүүлэлтүүд нь ерөнхий, өвөрмөц 2 хэсгээс бүрдэнэ.

3.2. Ерөнхий шалгуур үзүүлэлт нь тухайн төрлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын бүтэц, хүчин чадал, тусламж, үйлчилгээний чанарыг харуулна.

3.3. Өвөрмөц шалгуур үзүүлэлт нь тухайн төрлийн тусламж, үйлчилгээний онцлог, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэшсэн байдал, ур чадварыг харуулах бөгөөд үнэлэх шалгуур нь бүх эрүүл мэндийн байгууллагад ижил байна.

Шалгуур үзүүлэлтүүд		Мэдээллийн эх үүсвэр	Үнэлгээ
А. Хувийн хэвшлийн эмнэлэг			
1. Ерөнхий шалгуур үзүүлэлт:			
1	Тусгай зөвшөөрөлтэй байх	Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	Хангасан /хангаагүй
2	Магадлан итгэмжлэгдсэн байх	Магадлан итгэмжлэлийн батламж	Хангасан /хангаагүй
3	Зориулалтын байртай байх /орон сууцны барилга байгууламжаас ангид/	Эзэмшлийн болон түрээсийн гэрээ	Хангасан /хангаагүй
4	Мэргэжлийн хяналтын байгууллага МХБ/, Нийгмийн даатгалын байгууллагын/НДБ/ хяналт, шалгалтаар Эрүүл мэндийн багц хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын хууль, тэдгээрийг дагалдан гарсан тушаал шийдвэрийн хэрэгжилтэнд хангалттай үнэлгээ авсан байх. МХБ-с өгсөн хугацаат албан даалгаврын хэрэгжилт хангалттай байх	МХБ, НДБ-ын хяналт шалгалтын дүн, өгсөн албан даалгаврын хэрэгжилтийн хувь (орон нутгийн болон МХЕГ, НМХГ-ын хяналт шалгалтын сүүлийн 3 жилийн тайлан мэдээ)	Хангасан /хангаагүй
5	Их эмч болон эмнэлгийн мэргэжилтний 90-ээс доошгүй хувь нь үндсэн ажилтан байх	Байгууллагын даргын тушаал, хөдөлмөрийн гэрээ, нийгмийн даатгалын дэвтэр, эрүүл мэндийн даатгалын дэвтэр	Хангасан /хангаагүй
6	Үйлчлүүлэгчдэд зориулсан стандартын шаардлага хангасан гал тогоо, хүлээлгийн өрөө, сандал, угаалга, ариун цэврийн өрөө, бие засах суултууртай байх	Байгууллагын дотоод зохион байгуулалтыг харуулсан бүдүүвч зураг	Хангасан /хангаагүй
7	Эмнэлгээс шалтгаалсан халдварын/ЭШХ/ тохиолдлыг илрүүлэх, бүртгэх тогтолцоо бүрдсэн, бүртгэл хөтөлдөг, холбогдох байгууллагад мэдээлдэг байх	Халдвар хяналтын алба/багийн үйл ажиллагаа, ЭШХ-ын тохиолдлыг илрүүлэх бүртгэл ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны албаны мэдээ	Хангасан /хангаагүй
8	Байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийж, учирч болох эрсдэлийг бууруулах төлөвлөгөөтэй байх	Байгууллагын эрсдэлийг бууруулах төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан	Хангасан /хангаагүй

9	Эмнэлгийн чанарын албаны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг гаргаж дүгнэсэн байх	Чанарын албанаас хийх жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан /Сүүлийн 2 жилийн тайлан/	Хангасан /хангаагүй	
10	Эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагаа, статистик мэдээлэл, бүх төрлийн тайлан мэдээ бүрэн цахим хэлбэрт шилжсэн байх	Эмнэлгийн үйл ажиллагааны бүх төрлийн бүртгэл, мэдээ	Хангасан /хангаагүй	
2. Өвөрмөц шалгуур үзүүлэлт:				
1.Магадлан итгэмжлэлийн өвөрмөц шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байх				
1	Магадлан итгэмжлэлийн шалгуурын биелэлтийн хувь	96-100%	Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн дүгнэлт	2
		90-95 %		1
		85-89 %		0
2	Сонгон шалгаруулалтад заагдсан тусламж, үйлчилгээг үзүүлэх хүний нөөцийн бүтэцтэй байх	96-100%	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэх, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/ нотариатаар баталгаажсан хуулбар/ Гадаад, дотоодод чадавхжуулах сургалтанд хамргдсан гэрчилгээ Хүний нөөцийн тайлан	2
		90-95 %		1
		85-89 %		0
3	Сонгон шалгаруулалтад заагдсан тусламж, үйлчилгээг үзүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн нөөцтэй байх	96-100%	Орон нутгийн ЭМГ-ын төлөвлөгөөт хяналт, МХБ-ын хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн дүгнэлт Байгууллагын чанарын албаны жил бүрийн тайлан	2
		90-95 %		1
		85-89 %		0
4	Сонгон шалгаруулалтад заагдсан тусламж, үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт, эмнэлзүйн удирдамж, холбогдох стандартын хэрэгжүүлэлт	96-100%	Орон нутгийн ЭМГ-ын төлөвлөгөөт хяналт, МХБ-ын хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн дүгнэлт Байгууллагын чанарын албаны жил бүрийн тайлан	2
		90-95 %		1
		85-89 %		0
5	Мэргэжлийн нотлогдсон алдааны тоо	Алдаа гаргаагүй	Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын байгууллагад ирүүлсэн гомдолд хийсэн хяналт, шалгалтын дүн /Сүүлийн 2 жилээр /	2
		3 хүртэл		1
		3 ба түүнээс дээш		0
6	Эмнэлгийн мэргэжилтний ёсзүйн нотлогдсон алдааны тоо	Алдаа гаргаагүй	Эрүүл мэндийн яамны ёс зүйн хорооны хурлын тэмдэглэл, Мэргэжлийн хяналтын байгууллагад ирүүлсэн гомдолд хийсэн хяналт, шалгалтын дүн /Сүүлийн 2 жилээр /	2
		3 хүртэл		1
		3 ба түүнээс дээш		0
7	Тусламж, үйлчилгээний талаархи нотлогдсон өргөдөл, гомдлын тоо	Алдаа гаргаагүй	Эрүүл мэндийн байгууллагын дотоод хяналт, шалгалтын дүн /Сүүлийн 2 жилээр /	2
		3 хүртэл		1
		3 ба түүнээс дээш		0

8	Үйлчлүүлэгчийн өвчний түүх, бүрдүүлэлт, эмнэлзүйн стандарт, удирдамжийн хэрэгжүүлэлт	бүрэн	Боловсруулсан удирдамж, чанарын хяналтын тайлан, үйлчлүүлэгчийн карт, өвчний түүх	2
		бүрэн бус		1
		Огт		0
		байхгүй		0
9	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь /Сүүлийн 12 сараар/	80-аас дээш%	Тухайн байгууллагын өнгөрсөн хугацаанд авсан сэтгэл ханамжийн судалгааны дундаж	2
		75-80%		1
		75-аас доош%		0
10	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар ирүүлсэн санал, хүсэлтийг хэрэгжүүлсэн хувь	80-аас дээш%	Тухайн байгууллагын өнгөрсөн хугацаанд үйлчлүүлэгдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны дагуу хийсэн ажлын тайлан	2
		75-80%		1
		75-аас доош%		0
11	Хүний нөөцийн чадавхийг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь / Сүүлийн 2 жилээр /	96-100%	Хүний нөөцийн чадавхийг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан / он, оноор/	2
		90-95 %		1
		85-89 %		0

Б. Сувилал /Рашаан сувилал хамрагдана/

1.Ерөнхий шалгуур үзүүлэлт:

1.	Тусгай зөвшөөрөлтэй байх	Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээ	Хангасан /хангаагүй
2.	Магадлан итгэмжлэгдсэн байх	Магадлан итгэмжлэлийн батламж	Хангасан /хангаагүй
3.	Эрүүл агаарт зориулалтын байртай байх /хот суурин газраас 20-с доошгүй км хол байрладаг байх/	Газар эзэмшлийн болон түрээсийн гэрээ, зохих стандартын дагуу зохион байгуулсан ажлын байр	Хангасан /хангаагүй
4.	Мэргэжлийн хяналтын байгууллага /МХБ/, Нийгмийн даатгалын байгууллагын хяналт, шалгалтаар Эрүүл мэндийн багц хууль, Иргэний эрүүл мэндийн даатгалын хууль, тэдгээрийг дагалдан гарсан тушаал шийдвэрийн хэрэгжилтэнд хангалттай үнэлгээ авсан байх. МХБ-с өгсөн хугацаат албан даалгаврын хэрэгжилт хангалттай байх	МХБ, НДБ-ын хяналт шалгалтын дүн, өгсөн албан даалгаврын хэрэгжилтийн хувь (орон нутгийн болон МХЕГ, НМХГ-ын хяналт шалгалтын сүүлийн 2 жилийн тайлан мэдээ)	Хангасан /хангаагүй
5.	Их эмч болон эмнэлгийн мэргэжилтний 90-ээс доошгүй хувь нь үндсэн ажилтан байх	Байгууллагын даргын тушаал, хөдөлмөрийн гэрээ, контракт, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, эрүүл мэндийн даатгалын дэвтэр	Хангасан /хангаагүй
6.	Үйлчлүүлэгчдэд зориулсан стандартын шаардлага хангасан гал тогоо, ариун цэврийн өрөө, хоолны заалтай байх	Байгууллагын дотоод зохион байгуулалтыг харуулсан бүдүүвч зураг	Хангасан /хангаагүй
7.	Тусламж, үйлчилгээтэй холбоотой ЭШХ-ын тохиолдол бүртгэгдээгүй байх	Халдвар хяналтын алба/багийн үйл ажиллагаа, ЭШХ-ын тохиолдлыг илрүүлэх бүртгэл ХӨСҮТ-ийн Тандалт судалгааны албаны мэдээ	Хангасан /хангаагүй

8	Байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийж, учирч болох эрсдэлийг бууруулах төлөвлөгөөтэй байх	Тухайн байгууллагын эрсдэлийг бууруулах төлөвлөгөө	Хангасан /хангаагүй	
9	Эмнэлгийн өдөр тутмын үйл ажиллагаа, статистик мэдээлэл, бүх төрлийн тайлан мэдээ бүрэн цахим хэлбэрт шилжсэн байх	Эмнэлгийн үйл ажиллагааны бүх төрлийн бүртгэл, мэдээ	Хангасан /хангаагүй	
10	Рашааны ордыг гэрээгээр ашиглах тухай орон нутгийн эрх бүхий байгууллагын шийдвэртэй байх	Засаг даргын эсвэл, орон нутгийн ИТХ-ын шийдвэр	Хангасан /хангаагүй	
11	Тухайн рашааны ордын нөөц болон геологийн тогтоцын онцлог /хими физик чанар, эмчилгээний үйлчилгээ/ байдлын тухай мэргэжлийн байгууллагын дүгнэлттэй байх	Мэргэжлийн байгууллагын дүгнэлт	Хангасан/ хангаагүй	
12	Рашаан сувилал нь рашааныг ашиглах, хамгаалахтай холбогдон хийсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөртэй байх	Мэргэжлийн байгууллагын үнэлгээний дүн, төлөвлөгөө, хөтөлбөр	Хангасан /хангаагүй	
2.Өвөрмөц шалгуур үзүүлэлт:				
1. Магадлан итгэмжлэлийн өвөрмөц шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан байх				
1	Магадлан итгэмжлэлийн шалгуурын биелэлтийн хувь	96-100 %	Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн дүгнэлт	2
		90-95%		1
		85-89 %		0
2	Сонгон шалгаруулалтад заагдсан тусламж үйлчилгээг үзүүлэх мэргэшсэн хүний нөөцийн бүтэцтэй байх	96-100 %	Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн диплом, мэргэжлийн үнэмлэх, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл/ нотариатаар баталгаажсан хуулбар/ Гадаад, дотоодод чадавхжуулах сургалтанд хамрагдсан гэрчилгээ Хүний нөөцийн тайлан	2
		90-95%		1
		85-89 %		0
3	Сонгон шалгаруулалтад заагдсан тусламж үйлчилгээг үзүүлэх эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн нөөцтэй байх	96-100 %	Орон нутгийн ЭМГ-ын төлөвлөгөөт хяналт, МХБ-ын хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн дүгнэлт Байгууллагын чанарын албаны жил бүрийн тайлан	2
		90-95%		1
		85-89 %		0
4	Сонгон шалгаруулалтад заагдсан тусламж үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт, эмнэлзүйн удирдамж, холбогдох стандартын хэрэгжүүлэлт	96-100%	Орон нутгийн ЭМГ-ын төлөвлөгөөт хяналт, МХБ-ын хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн дүгнэлт Байгууллагын чанарын албаны жил бүрийн тайлан	2
		90-95 %		1
		85-89 %		0

5	Мэргэжлийн нотлогдсон алдааны тоо /Сүүлийн 2 жилээр /	Алдаа гараагүй	Эрүүл мэндийн яам, ирүүлсэн гомдолд хяналт, шалгалтын дүн	МХБ-д хийсэн	2
		3 хүртэл			1
		3 ба түүнээс дээш			0
6	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн нотлогдсон алдааны тоо/Сүүлийн 2 жилээр /	Алдаа гараагүй	Эрүүл мэндийн яамны ёс зүйн хорооны хурлын тэмдэглэл, МХБ-д ирүүлсэн гомдолд хийсэн хяналт, шалгалтын дүн		2
		3 хүртэл			1
		3 ба түүнээс дээш			0
7	Үйлчлүүлэгчийн картыг стандартын дагуу хөтөлсөн байдал, эмнэлзүйн удирдамж ашиглалт	бүрэн	Үйлчлүүлэгчийн карт, өвчний түүх		2
		бүрэн бус			1
		Карт хөтлөөгүй			0
8	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн хувь /Сүүлийн 12 сар/	80%-с дээш	Сэтгэл ханамжийн судалгааны тайлан		2
		80%-75 %			1
		75%-с доош			0
9	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар ирүүлсэн санал, хүсэлтийг хэрэгжүүлсэн хувь	80%-с дээш	Сэтгэл ханамжийн судалгааны дагуу хийсэн ажлын тайлан		2
		80-75 %			1
		75%-с доош			0
10	Хүний нөөцийн чадавхийг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь / Сүүлийн 2 жилээр/	96-100%	Хүний нөөцийн чадавхийг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан / Сүүлийн 2 жилээр/		2
		90-95 %			1
		85-89 %			0

Дөрөв. Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр тусламж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг үнэлэх аргачлал:

4.1. Сонгон шалгаруулалт явуулах тухай урилгыг комисс төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарлана. Урилгыг энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтад заасан загварын дагуу боловсруулна.

4.2. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүсэгч байгууллага нь урилгад заасан хугацааны дотор шалгуур үзүүлэлтийн ерөнхий, өвөрмөц хэсгийн үзүүлэлт тус бүрээр материалуудыг бүрдүүлж Сонгон шалгаруулах комисст хүлээлгэн өгнө. Үүнд:

- Сонгон шалгаруулалтад оролцох тухай байгууллагын хүсэлт;
- Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажилагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар;
- Магадлан итгэмжлэлийн батламжийн хуулбар;
- Эрүүл мэндийн байгууллагын байрны эзэмшлийн, эсхүл түрээсийн гэрээний хувь;

- 69
- Эрүүл мэндийн багц хууль тогтоомж, тэдгээрийг дагалдан гарсан тушаал шийдвэрүүд, бүтэц, үйл ажиллагааны (ариутгал, халдваргүйтгэл, хог хаягдал, гал тогоо,) болон оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн удирдамжийн хэрэгжилт, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамж, чанар аюулгүй байдлын талаар мэргэжлийн хяналтын байгууллага, Нийгмийн даатгалын байгууллагын гаргасан дүгнэлт, хугацаат албан даалгаврын хэрэгжилтийн тайлан;
 - Тухайн эрүүл мэндийн байгууллагын даргын бүтэц, орон тоо баталсан тушаал, ажилтнуудыг ажилд томилсон шийдвэр, ажиллагсадтай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, контракт, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;
 - Сонгон шалгаруулалтад заагдсан тусламж, үйлчилгээг үзүүлэх мэргэшсэн хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, эмнэлгийн тоног төхөөрөмжийн нөөцийн талаархи дэлгэрэнгүй тайлан, баримтууд;
 - Сонгон шалгаруулалтад заагдсан тусламж, үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой эрх зүйн баримт, эмнэлзүйн удирдамж, холбогдох стандартуудын хэрэгжилтийн дэлгэрэнгүй тайлан;
 - Тусламж, үйлчилгээний талаар нотлогдсон өргөдөл, гомдлын тоо, үүнээс: эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн нотлогдсон алдаа; мэргэжлийн нотлогдсон алдаа;
 - Үйлчлүүлэгчдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн, түүний дундаж хувь;
 - Сэтгэл ханамжийн судалгааны дагуу тухайн байгууллагад хийж гүйцэтгэсэн ажлын тайлан;
 - Байгууллагын тусламж, үйлчилгээний чанарын албаны өмнөх тайлант оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон биелэлтийн тайлан;
 - Хүний нөөцийн чадавхийг сайжруулах төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан;
 - Эмнэлгийн мэргэжилтнүүдийн багц цаг биелүүлэлтийн дэвтэр;
 - Байгууллагын зохион байгуулалтыг харуулсан бүдүүвч зураг;
 - Халдвар хяналтын алба/багийн үйл ажиллагааны тайлан, ЭШХ-ын тохиолдлыг илрүүлэх бүртгэл;
 - Байгууллагын эрсдлийн төлөвлөгөөний хуулбар, хэрэгжилтийн тайлан


4.3. Комисс нь шаардлага хангасан материалыг хүлээн авч Монгол улсын Засгийн газрын 2008 оны 172 дугаар тогтоолд заасан журмын дагуу үнэлгээг хийж, дүнг нэгтгэнэ.

4.4. Ерөнхий шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэхдээ хангасан, хангаагүй гэсэн үнэлгээ өгнө.

4.5. Өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг оноогоор дүгнэх бөгөөд шалгуурт заасантай тэнцүү буюу сайн байвал 2, дунд байвал 1, шалгуурт хүрэхгүй, сул дүнтэй байвал 0 оноо өгнө.

4.6. Ерөнхий шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангасан бөгөөд өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийн дүн нь 18-с дээш оноо авсан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг сонгон шалгаруулалтад тэнцсэн гэж үзнэ.

70
Эрүүл мэндийн сайдын
2013 оны 11 сарын 08 өдрийн
418 дугаар тушаалын
2 дугаар хавсралт



Загвар

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо: [Урилга нийтлэгдэх] _____

Үйл ажиллагааны нэр : _____

1. [Захиалагчийн нэр] нь эрх бүхий Сонгон шалгаруулалтад оролцогчдыг [Үйлчилгээний талаарх товч тодорхойлолт] үйлчилгээ үзүүлэх тухай Сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.
2. Сонгон шалгаруулалтад оролцох сонирхолтой эрүүл мэндийн байгууллага холбогдох баримт бичгийг бүрдүүлэн [Сонгон шалгаруулалт хүлээн авах эцсийн огноо, цаг] өмнө [Хүлээн авах байгууллагын нэр болон дэлгэрэнгүй хаяг]-д ирүүлнэ.
3. Сонгон шалгаруулалтад оролцоход бүрдүүлэх материалын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг [байгууллагын нэр болон хаяг] –аас авах боломжтой.

Эрүүл мэндийн сайдын
2013 оны 11 сарын 08 өдрийн
418 дугаар тушаалын
3 дугаар хавсралт

УЛС, БҮСИЙН ХЭМЖЭЭНД ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛДЭГ БОЛОН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга

Я.Буянжаргал

Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга;

Нарийн бичгийн дарга

М.Хишгээ

Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын Эмнэлгийн тусламж,
үйлчилгээний чанар, аюулгүй байдлын бодлогын
хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн ;

Гишүүд

Н.Тунгалаг, Эрүүл мэндийн яамны

Төрийн захиргаа удирдлагын газрын Байгууллагын
удирдлага, хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн;

С.Энхжин

Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ,
дотоод аудитын газрын мэргэжилтэн;

М.Оюунчимэг

Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын уламжлалт анагаах ухаан,
сэргээн засах тусламжийн бодлогын хэрэгжилтийн
зохицуулалт хариуцсан мэргэжилтэн ;

Б.Пүрэвжав

Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын Оношилгоо эмчилгээний
технологийн хэлтсийн мэргэжилтэн ;

Д.Амар

Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын Санхүү эдийн засгийн хэлтсийн
Эмнэлгийн тусламж үйлчилгээний төсвийн
төлөвлөлт, хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан
мэргэжилтэн ;

П.Мөнхтулга

Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын
дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газрын дэд
дарга (зөвшилцсөнөөр);

Ш.Оюунчимэг


Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эмнэлгийн
тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын
хяналтын улсын ахлах байцаагч (зөвшилцсөнөөр);

Д.Бямбасүрэн

Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн
байгууллагуудын нэгдсэн холбооны гүйцэтгэх
захирал (зөвшилцсөнөөр);

М.Авирмэд

“Эрүүл мэндийн байгууллагад эрх зүйн зөвлөгөө,
дэмжлэг үзүүлэх нийгэмлэг” Төрийн бус
байгууллагын тэргүүн (зөвшилцсөнөөр).



73
Эрүүл мэндийн сайдын
2013 оны 11 сарын 08 өдрийн
418 дугаар тушаалын
4 дүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНХҮҮЖИЛТЭЭР
ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ УЛС, БҮСИЙН ХЭМЖЭЭНД
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ БОЛОН ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТТАЙ
ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ КОМИССЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

№	Зардлын утга	Хэмжих нэгж хүн /цаг	Нэг бүрийн зардал/төг/	Бүгд зардал /төг/
1	Комиссын гишүүдийн ажлын хөлс	11хүн/ 16 цаг	1цаг * 2000	11 хүн * 32 000 төг= 352 000 төг
2	Бичиг хэргийн зардал			8 000 төг
3	Өдөр тутмын сонинд зар тавих	1 удаа		40 000
	Нийт зардал			400 000 төгрөг